



Хэвлэлийн мэдээ  
2016 оны 11-р сарын 24

Холбогдох утас:  
9710-9009

### **АмЧам Монгол Жилийн Тайлангийн Хурлаа Зохион Байгууллаа**

УЛААНБААТАР, Монгол улс - 2016 оны 11-р сарын 23-ны Лхагва гарагт Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь Жилийн Тайлангийн Хурлаа Туушин зочид буудалд зохион байгууллаа. Уулзалтанд Монгол улсад АНУ-аас суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Женифер Зимдал Галт болон АмЧамын гишүүд болон хувийн хэвшлийн төлөөлөгчдөөс бүрдсэн 50 гаруй зочид оролцож байгууллагын тэргүүлэх чиглэл, цаашдын ажлын зорилт чиглэлээ тодорхойлон санал хурааж ТУЗ-ийн бүрэлдэхүүндээ шинээр гурван гишүүн сонголоо.

АмЧамын ТУЗ-ийн сонгуульд нийт 7 гишүүн байгууллага гурван суудлын төлөө өрсөлдөнөөс Блүүмберг Монгол ТВ-ийн Гүйцэтгэх захирал ноён Э. Долгион, Ай Эн Жи Монголын Монголь дахь Суурин төлөөлөгч ноён Эрик Версавел болон Эм Си Эс Холдинг компаний дэд захирал ноён Э. Эсэнцэнгэл нар олонхийн санал авч сонгогдлоо.

АмЧам Монголын ТУЗ-ийн дарга ноён Жэймс Лиотта арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “2016 он бол АмЧамын хувьд онцлох жил байлаа. Бид шинээр 13 гишүүн элсүүлж, нийтдээ 33 арга хэмжээ зохион байгуулж, бодлогын чиглэлд голлох 6 Бодлогын баримт бичгийг гаргалаа. Мөн түүнчлэн өмнөх болон одоогийн Ерөнхий сайд, шинээр томилогдсон Гадаад харилцааны сайд болон Сангийн дэд сайдтай хамгийн түрүүнд уулзалт зохион байгуулсан бизнесийн байгууллага боллоо. 2017 онд бид энэ жил суурийг нь тавьсан олон чухал ажлуудаа гишүүдийнхээ өмнөөс бодит үйл хэрэг болгохын төлөө ажиллах болно” гэсэн юм.

Монгол улсад АНУ-аас суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд хатагтай Женифер Зимдал Галт хэлсэн үгэндээ “2017 онд бид АНУ-Монголын харилцааг улам өргөжүүлэхийн сацуу хамтын зорилго, зорилтуудаа биелүүлэхээр АмЧамтай нягт хамтран ажилласаар байх болно гэдэгт гүнээ итгэж байна. Шинэ онд бид нэгэнт тогтсон бат бэх түншлэлийн харилцаагаа улам бэхжүүлж, хамтын ажиллагааны шинэ чиглэлүүдийг нээн ажиллана гэдэгт итгэлтэй байна” гэсэн юм.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.